



Thomas Jefferson Middle School

IB MYP-ийн 11-р сарын мэдээллийн хуудас



Өөрсдийгөө, ирээдүйгээ, дэлхий ертөнцөө ойлгож сайжруулахын төлөө хамтдаа суралцаж байна.

Энэ сарын шилдэг сурагч: ЭРЭН СУРВАЛЖЛАГЧ

Сурах бүх үйл явц эрэн сурвалжлагаас эхлэх хэрэгтэй. Бид эрэн сурвалжлагч болохын хувьд “сониуч зангаа” дээшлүүлж, судлах чадвараа хөгжүүлэхийг зорьдог. Бид өөрийнхөө хүчээр болон бусадтай хамтран суралцахыг сурдаг. Бид насан туршдаа сурч боловсрохын төлөө байдаг.



Манай эрэн сурвалжлагч сурагчид бол **Dolphins - Omayma Paredes, Dragons - Mila Djarimbetova, Eagles - Kimberly Jimenez, Gators - Abe Sawez, Monarch - Uriel Guasti Ortiz, Owl - Rhys Harbour, Penguins - Abigail Putnam, Phoenix - Brandon Tamir, and Stingrays - Abeer Zafar** нар юм.

Эх сурвалж: <https://pixabay.com/photos/animals-dog-cat-puppy-young-2198994/>

Өөрийгөө дүгнэх, сургуулийг сайжруулах

Манай Jefferson сургуулийн хувьд өөртөө дүгнэлт хийх цаг ирлээ. Энэ сараас эхлэн ОУБ-ын Дунд сургуулийн хөтөлбөрийг хэр сайн хэрэгжүүлж байгаа талаар санал хүсэлт авах зорилгоор цуврал судалгааг Jefferson сургуулийн бүх багш, сурагч, эцэг эхэд илгээнэ. Энэ судалгаа нь манай үнэлгээний үе шат эхлэхээс өмнө заах, суралцах үйл явцын талаар эргэцүүлэн бодож, үнэлэлт өгөх ажлын нэг чухал хэсэг юм.

Өөрийгөө дүгнэх үйл явцын үеэр сонгосон хариултын зэрэглэл бүхий асуулт, мөн илүү дэлгэрэнгүй хариулах асуултыг хослуулж асууна. Сургуулийн зарчим, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр (заах, суралцах, үнэлгээг багтаана) зэрэг сэдвүүд байна. Бид амжилтаа тэмдэглэж, цаашид анхаарах асуудалд төвлөрөхийн тулд шударга, илэн далангүй санал зөвлөмж авахыг хүсэж байна.

Үнэлгээний том дүр зураг



Багш нар эхэлж шалгалтын материалаа төлөвлөж, дараа нь тэдгээр даалгаврыг сурагчдаар амжилттай хийлгэхийн тулд хичээлээ төлөвлөх нь зүйтэй гэсэн санаа нь “backward design” арга

барилын цөм юм. Гэвч “backward design” арга барил жигд хэрэгжихгүй байна. Бид зөвхөн бүлгийн түвшинд бус бүхэл жилийг харгалзан “backward design” арга барилыг ашиглах нөхцөл бүрдүүлэхийг зорьж байна. ОУБ-ын шалгууруудыг шинжлэн үзэж, шалгуур бүрийг ямар бүлэг сэдэвт үнэлэх вэ гэдгээ бодохыг багш нараас шаардаж байгаа. (жилийн туршид доод тал нь хоёр удаа). Үүний гол зорилго нь дүнг хэрхэн тодорхойлох гэдэг дээр ил тод байхад оршиж байна. Хамгийн өндөр түвшинд хүрэхийн тулд сурагч юуг хийх чадвар эзэмшсэн байх хэрэгтэй вэ гэдгийг харуулсан шалгуурт суурилсан зааврыг танилцуулж, бүлэг сэдэв бүрийг эхлэх хэрэгтэй.

Эх сурвалж: pixabay.com

MYP-ийн анги, бодит үнэлгээ

Талархлын баярын аварга хулууны бялуу идэх, тооны хичээлээ хийх хоёр нь хоорондоо нэг их авцалдмааргүй боловч манай MYP 1, 6-р ангийн сурагчид яг л тийм зүйл хийлээ. DeMao багшийн ангид сурагчид хэсэг бүлгээрээ Аварга хулууны бялуу идэх уралдаанд оролцсон. Сурагчдыг ОУБ-ын математикийн D шалгуураар үнэлсэн: Бодит амьдралд математик сэтгэлгээг ашиглах. Сурагчдад бялуу хийх жор өгсөн бөгөөд тэд жорд зааснаас илүү олон зочдыг дайлахын тулд их хэмжээгээр хийх хэрэгтэй байв. Сурагчид математикийн хэмжих нэгжийг шилжүүлж, дараа нь илүү том хэмжээтэй бялуу хийх хэрэгтэй болов. Энэ сонинг хэвлэх үед бялуу арай бэлэн болоогүй байсан ч гайхалтай үнэртэж байлаа.



Олон нийтийн төсөл

Олон нийтийн төсөл одоо хүчээ авч байна. Иргэдийн хэрэгцээ шаардлагыг судалж, хангахаар сонгож, хуваарилан авсан 176 сурагч байна. Амьтанд туслах, орон гэргүй хүмүүст туслах, дэлхийн дулааралд анхаарах, биеийн тамир тэнхээг сурталчлах, хананд зураг зурж будах зэрэг сэдвээр төсөл хэрэгжүүлж эхэлсэн 9 бүлэг байгаа. Урьдын адил амьтанд туслах нь хамгийн түгээмэл сэдэв боловч төөрсөн нохой, мууранд туслахын тулд зөвхөн бялуу зарах бус ховордсон амьтны төрөл зүйлийн талаар мэдлэг боловсрол олгох зорилготой юм. Манай 8-р ангийнхан иргэдэд туслах санаагаа ажил хэрэг болгож байна.



Үйлчилгээнд суралцах

7-р ангийн сурагч Lincoln Eberly, Jason Spitzak нарын санаачилсан Jefferson сургуулийн Байгаль орчны клуб 11-р сарын 22-ны Баасан гарагт мод тарих мөнгө цуглуулахын тулд анх удаагаа бялуу зарсан. Байгаль орчны клубийн сурагчид Пүрэв гараг бүр уулзаж байна. Тэд EcoArllignton байгууллагын дарга Hodges, Voggan нартай уулзалт зохион байгуулсан. Тэд уур амьсгалын хямралын талаар уншиж, дорвитой арга хэмжээ авахад бэлэн байна. Эдгээр үйл ажиллагаанд зөвхөн мод тариад зогсохгүй мөн 2050 он гэхэд 100 хувь сэргээгдэх эрчим хүч ашиглах зорилго тавихад Арлингтон хотоос үлгэр дуурайлал авахыг Виржиниа мужид уриалж хүсэхээр Ерөнхий чуулганд захидал хүргүүлэх багтана.



Jefferson сургууль орон нутагт

Jefferson сургуулийн сурагч бүр бодит амьдрал дээр суралцах ямар байдгийг мэдрэх зорилготой аяллаар явсан. 10-р сарын 24-нд манай 7-р ангийн сурагчид Смитсонийн Америкийн урлаг, Байгалийн түүхийн музей үзсэн. 11-р сарын 1-нд манай 6-р ангийн сурагчид амьд амьтан, байгалийн талаар сонирхохоор ферм уруу явсан. Мөн 11-р сарын 4-нд манай 8-р ангийн сурагчид урт хугацааны боловсролыг хаана эзэмшихээ сонгохоор 9 өөр коллеж дээр очиж үзсэн.



Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

- Мягмар гараг бүр 17:00 цагт унадаг дугуй засахад сайн дураар туслах ажил Phoenix Bikes дэлгүүр дээр, 909 S. Dinwiddie St ([дэлгэрэнгүйг эндээс](#))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлахад сайн дураар туслах ажил AFAC дээр, 2708 S. Nelson St, ([дэлгэрэнгүйг эндээс](#))
- Пүрэв гараг бүр хичээлийн дараа 264 тоот танхимд Ноён Malinosky-тай хамт Jefferson сургуулийн байгаль орчны клуб дээр очоорой
- 8-р ангийнхан Олон нийтийн төслийн зорилгыг эцэслэнэ.